



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 4 сарын 27 өдөр

Дугаар 2


Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27<sup>1</sup>.1.9 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Мал, амьтны гоц халдварт өвчний үед шалган нэвтрүүлэх цэгийн ажиллах нийтлэг заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН



Улсын онцгой комиссын  
даргын 2023 оны 4 дүгээр  
сарын 17-ны өдрийн 2 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

УХА0168

## МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ҮЕД ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЦЭГИЙН АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Мал, амьтны гоц халдварт өвчний үед хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах зорилготой шалган нэвтрүүлэх цэгийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Энэхүү зааврыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэн өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

Хоёр. Шалган нэвтрүүлэх цэгийн удирдлага зохион байгуулалт:

2.1. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар, шалган нэвтрүүлэх болон хяналтын цэг /хөдөлгөөнт эргүүл/-ийг байгуулна;

2.2. Засаг даргын захирамжид голомтын болон сэжигтэй бүсийн зааг, шалган нэвтрүүлэх цэгийн байршил, ажиллах хүн, хүч хэрэгсэл, шаардлагатай зардал, мөрдөх тусгай горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тусгана;

2.3. Шалган нэвтрүүлэх цэг нь зайлшгүй шаардлагаар голомтын бүсээс гарах хүн, тээврийн хэрэгслийг халдваргүйтгэх үйл ажиллагааг хариуцна;

2.4. Шалган нэвтрүүлэх цэг нь суурин болон хөдөлгөөнт хэлбэртэй байна. Суурин цэгээр мал эмнэлгийн хорио цээр, хяналтын цэг, замын цагдаагийн шалган нэвтрүүлэх пост зэрэг барилга, байгууламжийг, хөдөлгөөнт нь монгол гэр, зөөврийн сууц, майхан зэргийг ашиглаж болно;

2.5. Хяналтын цэг /хөдөлгөөнт эргүүл/ нь хорио цээрийн дэглэм тогтоосон бүсээс орох, гарах хөдөлгөөнийг бүрэн хориглоно;

2.6. Шалган нэвтрүүлэх болон хяналтын цэг /хөдөлгөөнт эргүүл/ нь тээврийн хэрэгсэлтэй байна;

2.7. Шалган нэвтрүүлэх цэг нь дэргэдээ халдваргүйтгэлийн байртай байна;

2.8. Халдваргүйтгэлийн байр нь улирлын онцлогоос хамааран автомашин бусад тээврийн хэрэгсэл туулах ванн, автомакс, мананцаржуулагч, хүний хувцас хэрэгслийг халдваргүйтгэх багаж төхөөрөмжөөр хангагдсан байна;

2.9. Шалган нэвтрүүлэх цэгийн өдөр тутмын үйл ажиллагааг Мал эмнэлгийн байгууллагын ажилтан /мал эмнэлгийн улсын байцаагч/ удирдан зохион байгуулна;

2.10. Иргэн, хуулийн этгээд зайлшгүй шаардлагаар хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутгаас гарах, дамжин өнгөрөх тохиолдолд нутгийн захиргааны байгууллагаас тогтоосон тусгай горимыг дагаж мөрдөнө;

2.11. Шалган нэвтрүүлэх цэгийн байранд согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхийг хориглоно;



2.12. Шалган нэвтрүүлэх цэгт ажиллах ажилтан, албан хаагч, иргэн хантааз (гэрэл ойлгогчтой), шүгэл, гэрэлтүүлэг бүхий дохиур ашиглаж болно.

Гурав. Шалган нэвтрүүлэх цэгт тавигдах шаардлага:

3.1. Шалган нэвтрүүлэх цэгийн байр алсаас харагдахуйц тэмдэг, тэмдэглэгээтэй, гадуураа тэг, гортиг татаж, хүн, тээврийн хэрэгсэл нэвтрэх тусгай орц, гарцтай байх;

3.2. Шалган нэвтрүүлэх цэгийн байранд тухайн өвчинтэй тэмцэх заавар, холбогдох хууль, дүрэм, журам, Засаг даргын захирамж зэргийг агуулсан самбар байгуулах;

3.3. Шалган нэвтрүүлэх цэгийн байршлаас 100 болон 300 метрийн зайд "ХЯНАЛТЫН ЦЭГ-100 метр", "ХЯНАЛТЫН ЦЭГ-300 метр" гэсэн тэмдэг, 20-50 метрийн зайд "ОРОХЫГ ХОРИГЛОНО" гэсэн тэмдэг тус тус байршуулах;

3.4. Шалган нэвтрүүлэх цэгийн суурин байр "Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм" MNS 5566:2020 стандартын дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан байх;

3.5. Шалган нэвтрүүлэх цэгийн суурин байрны цахилгааны угсралтын ажлыг цахилгаан байгууламжийн дүрэм (БД 43-101-03)-ийн дагуу хийж галын аюулгүй байдлыг хангасан байх;

3.6. Шалган нэвтрүүлэх цэгийн суурин байрыг "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" БНБД 21-04-05 барилгын норм ба дүрмийн дагуу гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгслээр тоноглох;

3.7. Шаардлагатай тохиолдолд шалган нэвтрүүлэх цэгийн суурин байранд мэргэжлийн байгууллагаар галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан байх;

3.8. Шалган нэвтрүүлэх цэг нь бие засах газар, аюултай болон энгийн хог хаягдал хаях, устгах цэгтэй байх бөгөөд цогтой үнс, нурам хийх тагтай төмөр сав байрлуулсан байх;

3.9. Шалган нэвтрүүлэх цэг нь холбоо, мэдээллийн хэрэгсэлтэй байх.

Дөрөв. Нийтлэг эрх

4.1. Авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах;

4.2. Шалган нэвтрүүлэх цэгээр дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг зогсоох, шалгах, иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих;

4.3. Хорио цээрийн дэглэм зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хяналт тавих, холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

Тав. Байгууллага, албан хаагчдын эрх, үүрэг

5.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Онцгой комисс:

5.1.1. Шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэх албан хаагч, иргэнийг тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

5.1.2. Дайчлагдан ажилласан иргэн, албан хаагчдад олгох томилолтын зардлыг шийдвэрлэх;



5.1.3. Үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай орон байр, хоол хүнс, шатах тослох материал, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисоор хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

5.1.4. Харилцаа холбооны сүлжээгүй орон зайд шалган нэвтрүүлэх цэгийг байгуулсан тохиолдолд холбогдох гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг дайчлан холбоо зохион байгуулах;

5.1.5. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм, мал, амьтны гоц халдварт өвчний талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгөх;

5.1.6. Шалган нэвтрүүлэх цэгт ажиллах ажилтан, албан хаагчийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах;

5.1.7. Шалган нэвтрүүлэх цэгийн байранд үүрэг гүйцэтгэх албан хаагчдын ажил үүргийн хуваарийг баталж, мөрдүүлэх;

5.1.8. Зайлшгүй шаардлагаар шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэх иргэн, тээврийн хэрэгсэлд мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн зөвшөөрөл олгох;

5.1.9. Шалган нэвтрүүлэх цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгах.

#### 5.2. Мал эмнэлгийн байгууллага:

5.2.1. Голомтын бүсэд ажиллаж байгаа малын эмч мэргэжилтнийг мэргэжлийн удирдлагаар хангах;

5.2.2. Шалган нэвтрүүлэх цэгт халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах;

5.2.3. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хорио цээрийн дэглэмийн талаар иргэд, олон нийтэд сурталчлах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгөх;

5.2.4. Халдваргүйтгэлийн бодис, уусмал найруулах, хадгалах, зөөвөрлөх, халдваргүйтгэх үед нэг удаагийн халдвар хамгааллын хувцас тогтмол өмсөж хэрэглэх;

5.2.5. Өвчний голомтоос мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний шилжилт, хөдөлгөөн /мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир г.м/-ийг хориглох, хяналт тавих;

5.2.6. Өвчний голомтоос ирүүлсэн сорьц, дээжид халдваргүйтгэл хийж мал эмнэлгийн лабораторид хүргүүлэх;

5.2.7. Халдваргүйтгэлийн суурин болон зөөврийн төхөөрөмжийг ажиллуулах;

5.2.8. Зайлшгүй шаардлагаар шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, хүний хувцас хэрэгсэлийг стандартын дагуу халдваргүйтгэх, бүртгэл хөтлөх;

5.2.9. Нэг удаагийн халдвар хамгааллын хувцас хэрэгсэл урагдсан, цоорсон, их хэмжээгээр бохирлогдсон тохиолдолд холбогдох зааврын дагуу устгах;

5.2.10. Халдварын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын хамгаалах хувцас, хэрэгсэл (өмсөх, тайлах, халдваргүйтгэх, устгах) үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж өгөх;

5.2.11. Мэдээ, мэдээллийг нэгтгэж, өдөр тутам холбогдох байгууллагад хүргүүлэх, нэгдсэн мэдээллээр хангах;

5.2.12. Тухайн бүс нутагт хэрэгжиж байгаа хорио цээрийн дэглэм, Засаг даргын захирамж болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Мал, амьтны эрүүл мэндийн хуулийн дагуу хариуцлага тооцох.



### 5.3. Онцгой байдлын байгууллага:

5.3.1. Аймаг, сумын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

5.3.2. Шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэх ажилтан, алба хаагч, иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, зааварчилгааг өгч, гарын үсгээр баталгаажуулах, биелэлтийг хянах;

5.3.3. Өвчний талаарх мэдээ, мэдээллийг авах;

5.3.4. Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсээс зайлшгүй шаардлагаар шалган нэвтрүүлэх цэгээр дамжин гарах иргэний талаар онцгой комисст мэдэгдэх, шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.3.5. Холбогдох албан тушаалтныг мэдээ мэдээллээр тухай бүр шуурхай хангах, нөхцөл байдлыг орон зай мэдээллийн системд оруулах;

5.3.6. Голомтын бүс дэх иргэдийн хүнс, бараа, хүн, мал эмнэлгийн эм тариа, багаж, тоног төхөөрөмжийг тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д сэлгүүлэн буулгах, ачихад хяналт тавих.

### 5.4. Цагдаагийн байгууллага:

5.4.1. Зорчих хөдөлгөөний замын зураглал гаргах, явах чиглэлийг тодорхойлох, зорчих хөдөлгөөнийг зохицуулах;

5.4.2. Шалган нэвтрүүлэх цэгт хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

5.4.3. Голомтын бүсэд гаднаас хүн, тээврийн хэрэгсэл, мал, амьтан оруулах, гадагш гаргахгүй байхад хяналт тавих;

5.4.4. Хууль, дүрэм, заавар зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллага (хуулийн этгээд)-д Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох.

### 5.5. Эрүүл мэндийн байгууллага:

5.5.1. Шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж буй ажилтан, албан хаагч, иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх;

5.5.2. Зайлшгүй шаардлагаар шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэх иргэнд халдвар хамгааллын дэглэм сахиулах;

5.5.3. Үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад хордлого, харшлын шинж тэмдэг илэрсэн үед анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай тохиолдолд дээд шатны эрүүл мэндийн байгууллагад хандах;

5.5.4. Шалган нэвтрүүлэх цэгт эмнэлгийн анхан шатны тусламжийн нөөцийг бүрдүүлэх, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

### 5.6. Иргэн, аж, ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг:

5.6.1. Хорио цээрийн дэглэмийг чанд сахих, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дагаж мөрдөх;

5.6.2. Хорио цээрийн дэглэм, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.



Улсын онцгой комиссын даргын  
2023 оны 7 дүгээр сарын 27-ны  
өдрийн 27 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

УХАД168

(Загвар)

## НЭВТРЭХ ЗӨВШӨӨРӨЛ

..... АЙМАГ (СУМ)-ЫН ОНЦГОЙ КОМИСС

Дугаар .....

.... аймгийн .... сумын Онцгой комиссын 20.. оны ... дугаар сарын ....-ны  
өдрийн ... дугаар хурлын тэмдэглэлийн .... –т заасныг үндэслэн 20.. оны ... дугаар  
сарын ... өдрүүдэд .....

.....  
шалтгаанаар ..... овогтой ..... загварын .....  
улсын дугаартай тээврийн хэрэгслээр ..... чиглэлд /орох, гарах/  
шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх зөвшөөрөл олгов.

Хамт зорчих зорчигчдын нэрс .....

Зөвшөөрөл олгосон:

..... АЙМАГ (СУМ)-ЫН ОНЦГОЙ КОМИСС

(албан тушаалтны нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал)

20... оны ... дугаар сарын .... -ны өдөр